

# ХААН СОЁМБО АУДИТ ХХК



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Арбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/130/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Хөвсгөл аймаг  
2022 он

Аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар  
Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр  
Утас: 99089114 Цахим хаяг: [tegshdelgerb@audit.gov.mn](mailto:tegshdelgerb@audit.gov.mn)

Аудитор: Г.Ичинхорлоо  
Утас: 88012671 Цахим хаяг: [ichinkhorloog@audit.gov.mn](mailto:ichinkhorloog@audit.gov.mn)

Хаан соёмбо аудит ХХК-ын захирал: Х.Диймаа  
Утас: 99065668 Цахим хаяг: [info@khaansoyomboaudit.mn](mailto:info@khaansoyomboaudit.mn)

Гүйцэтгэсэн аудитын менежер: Л.Магсаржалам  
Утас: 88114867 Цахим хаяг: [khaan.soyombo.audit@gmail.com](mailto:khaan.soyombo.audit@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1.АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	15
3.5.1 Төсвийн төлөвлөлт.....	15
3.5.2 Төсвийн гүйцэтгэл .....	16
3.5.3 Нэмэлт төсөв .....	16
3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн.....	16
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	16
4.1 Ерөнхий зүйл .....	16
4.2 Материаллаг байдал.....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	17
4.5.1 Завсрын аудитын талаар .....	17
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	18
5.1 Төлбөрийн акт .....	18
5.2 Албан шаардлага .....	18
5.3 Зөвлөмж.....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	19

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120

Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvs gul@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

2023.02.24 № 01/185  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН АРБУЛАГ СУМЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА  
Т.ЦЭЦЭГМАА ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Арбулаг сумын Эрүүл Мэндийн Төв-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Арбулаг сумын Эрүүл Мэндийн Төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэлийг 2022 оны 1 дүгээр сарын 1-ны өдрөөс эхлэн хэрэгжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд зарцуулах хөрөнгийг эрүүл мэндийн даатгалын санд нэгтгэж, гүйцэтгэлд суурилан санхүүжүүлсэн байна. Тус байгууллага нь гүйцэтгэлээр санхүүжилт авсан боловч мөнгөн хөрөнгийн дансанд 54,140.8 мянган төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдэлтэй байна.

### Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтийг гүйцэтгэлд суурилж олгож байгаагаас шалтгаалан, санхүүжилтийн орлого нэмэгдэж ирснээр дахин эм, багаж тоног төхөөрөмжийн тендер зарлаж, худалдан авалт хийх шаадлагатай байсан ч, тухайн сумын Эрүүл мэндийн төв нь 30,032.8 мянган төгрөгийн эм, 36,451.1 мянган төгрөгийн багаж тоног төхөөрөмж нийт 66,483.9 мянган төгрөгийн шууд худалдан авалт хийсэн байна.

### Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2022 онд 2 зорилтын хүрээнд 43 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж 95.6 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

СТ-1А

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>130,744,429.03</b>	<b>124,581,048.41</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	237,503.21	54,140,825.00
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	237,503.21	54,140,825.00
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	237,503.21	54,140,825.00
31211	Төрийн сангийн харилцах	00.21	54,140,825.00
31213	Арилжааны банк дахь харилцах	237,500.00	00.00
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	03.00	00.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	32,767,600.00	00.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	32,767,600.00	00.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	97,739,325.82	70,440,223.41
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	48,320,886.14	46,203,174.56
35130	Эм боох материал	48,320,886.14	46,203,174.56
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	49,418,439.68	24,237,048.85
35410	Бичиг хэргийн материал	1,802,710.00	1,612,200.00
35420	Аж ахуйн материал	4,709,970.20	4,647,415.00
35440	Түлш, шатах тослох материал	8,664,092.50	1,988,790.00
35460	Хүнсний материал	4,478,401.11	5,225,462.69
35470	Бусад хангамжийн материал	29,763,265.87	10,763,181.16
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>340,780,980.20</b>	<b>415,618,458.37</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	340,780,980.20	415,618,458.37
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	325,671,130.11	400,590,008.24
39201	Барилга, байгууламж, орон сууц	225,818,575.10	225,696,975.10
39202	Хуримтлагдсан элэгдэл	-36,361,757.79	-48,634,142.51
39203	Авто-тээврийн хэрэгсэл	46,426,896.00	116,426,896.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-28,728,597.76	-40,906,264.38
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	128,781,065.56	186,494,722.85
39206	Хуримтлагдсан элэгдэл	-23,647,265.77	-50,774,356.39
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	19,119,875.00	19,250,315.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-5,737,660.23	-7,334,137.43
39214	Бусад үндсэн хөрөнгө	407,991.00	370,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-407,991.00	00.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	15,109,850.09	15,028,450.13
39303	Бусад биет бус хөрөнгө	15,293,000.00	15,293,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-183,149.91	-264,549.87
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>471,525,409.23</b>	<b>540,199,506.78</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>471,525,409.23</b>	<b>540,199,506.78</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	471,525,409.23	540,199,506.78
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	263,741,078.00	263,741,078.00
51101	Өмч: - төрийн	263,741,078.00	263,741,078.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	51,446,000.85	120,120,098.40

Арбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

51210	Өмнөх үеийн үр дүн	51,446,000.85	51,446,000.85
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	68,674,097.55
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	156,338,330.38	156,338,330.38
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>471,525,409.23</b>	<b>540,199,506.78</b>

**СТ-2А**

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

/Төгрөгөөр/			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>958,519,701.01</b>	<b>819,228,980.55</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>361,814,101.01</b>	<b>148,603,540.55</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	361,814,101.01	148,603,540.55
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	361,814,101.01	148,603,540.55
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	257,031,105.45	147,438,440.55
1200042	Туслах үйл ажиллагааны орлого		1,165,100.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>596,705,600.00</b>	<b>670,625,440.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	405,519,800.00	00.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	137,022,150.00	00.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	360,500.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	25,393,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,951,950.00	00.00
131106	Төсвийн урамшуулал		
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	16,450,000.00	35,275,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	16,450,000.00	35,275,200.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	37,713,650.00	635,350,240.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	37,713,650.00	635,350,240.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>793,130,319.48</b>	<b>750,554,883.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>793,130,319.48</b>	<b>750,554,883.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	769,130,319.48	748,038,925.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	343,755,803.79	352,702,104.00
210101	Үндсэн цалин	204,616,255.32	230,925,176.68
210102	Нэмэгдэл	83,894,356.73	71,741,260.11
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	3,756,000.00
210104	Урамшуулал	38,592,663.56	30,992,082.21
210105	Гэрээт ажлын хөлс	16,652,528.18	15,287,585.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	47,091,550.00	45,859,600.00
210201	Тэтгэврийн даатгал	34,237,650.00	31,915,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,213,600.00	3,486,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,570,800.00	2,788,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	642,200.00	697,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,427,300.00	6,972,000.00

Арбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	15,230,861.50	23,867,802.50
210301	Гэрэл, цахилгаан	2,534,849.00	3,276,469.00
210302	Түлш, халаалт	12,696,012.50	20,417,802.50
210303	Цэвэр, бохир ус	00.00	173,531.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	43,020,320.00	62,037,389.28
210401	Бичиг хэрэг	4,139,510.00	4,552,670.21
210402	Тээвэр, шатахуун	24,798,389.00	30,274,750.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,065,000.00	3,069,999.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	242,000.00	1,855,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,834,121.00	22,284,970.07
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	275,347,601.73	144,387,926.67
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	266,807,599.00	105,991,384.25
210502	Хоол, хүнс	8,540,002.73	27,296,042.42
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	11,100,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	3,500,000.00	43,258,235.43
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	19,279,335.43
210604	Урсгал засвар	3,500,000.00	23,978,900.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,134,000.00	1,828,000.00
210702	Дотоод албан томилолт	1,134,000.00	1,828,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,182,660.00	5,712,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	3,000,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	1,170,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	54,450.00	54,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	44,500.00	44,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.00	33,000.00
210807	Газрын төлбөр	148,900.00	148,900.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	501,810.00	1,261,550.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	38,867,522.46	68,385,467.12
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,032,831.00	9,976,288.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	29,834,691.46	58,409,179.12
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	24,000,000.00	2,515,958.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	24,000,000.00	237,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	24,000,000.00	237,500.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	00.00	2,278,458.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	2,278,458.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>165,389,381.53</b>	<b>68,674,097.55</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	11,250,000.00	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	11,250,000.00	00.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-11,250,000.00	00.00
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>154,139,381.53</b>	<b>68,674,097.55</b>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>564,064,280.00</b>	<b>704,558,140.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>33,932,700.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	00.00	33,932,700.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	33,932,700.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>564,064,280.00</b>	<b>670,625,440.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	405,519,800.00	00.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	104,380,830.00	00.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	360,500.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	25,393,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,078,230.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	16,450,000.00	35,275,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	16,450,000.00	35,275,200.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>37,713,650.00</b>	<b>635,350,240.00</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	37,713,650.00	635,350,240.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>560,282,776.79</b>	<b>612,930,118.21</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>560,282,776.79</b>	<b>612,930,118.21</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>536,282,776.79</b>	<b>610,414,160.21</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	343,755,803.79	352,702,104.00
210101	Үндсэн цалин	204,616,255.32	230,925,176.68
210102	Нэмэгдэл	83,894,356.73	71,741,260.11
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	3,756,000.00
210104	Урамшуулал	38,592,663.56	30,992,082.21
210105	Гэрээт ажлын хөлс	16,652,528.18	15,287,585.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	47,091,550.00	45,859,600.00
210201	Тэтгэврийн даатгал	34,237,650.00	31,915,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,213,600.00	3,486,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,570,800.00	2,788,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	642,200.00	697,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,427,300.00	6,972,000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	20,694,764.00	17,150,000.00
210301	Гэрэл, цахилгаан	2,534,849.00	3,276,469.00

Арбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210302	Түлш, халаалт	18,159,915.00	13,700,000.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	173,531.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>41,163,034.00</b>	<b>59,435,319.21</b>
210401	Бичиг хэрэг	4,725,504.00	4,000,000.21
210402	Тээвэр, шатахуун	25,030,439.00	30,274,750.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,065,000.00	3,069,999.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	254,000.00	7,341,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,088,091.00	14,749,570.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>60,651,649.00</b>	<b>92,093,327.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	48,885,649.00	54,239,227.00
210502	Хоол, хүнс	10,766,000.00	28,437,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00	9,416,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>10,840,000.00</b>	<b>26,500,000.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	7,340,000.00	12,000,000.00
210604	Урсгал засвар	3,500,000.00	14,500,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,344,000.00</b>	<b>1,828,000.00</b>
210702	Дотоод албан томиллолт	1,344,000.00	1,828,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,322,050.00</b>	<b>6,598,510.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	3,000,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	1,170,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	54,450.00	54,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	44,500.00	44,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.00	33,000.00
210807	Газрын төлбөр	148,900.00	148,900.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	641,200.00	2,147,660.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>9,419,926.00</b>	<b>8,247,300.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,419,926.00	8,247,300.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>24,000,000.00</b>	<b>2,515,958.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>24,000,000.00</b>	<b>237,500.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	24,000,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	237,500.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>00.00</b>	<b>2,278,458.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	2,278,458.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>3,781,503.21</u></b>	<b><u>91,628,021.79</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>3,544,000.00</b>	<b>37,724,700.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>3,544,000.00</b>	<b>37,724,700.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>3,544,000.00</b>	<b>37,724,700.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,544,000.00	37,724,700.00

6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<b>-3,544,000.00</b>	<b>-37,724,700.00</b>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	237,503.21	53,903,321.79
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	237,503.21
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	237,503.21	54,140,825.00

СТ-4А

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/					
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	281,291,214.00	137,891,434.83	-95,067,350.76	324,115,298.07
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	281,291,214.00	137,891,434.83	-95,067,350.76	324,115,298.07
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	5,374,753.43	5,374,753.43
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	263,741,078.00	156,338,330.38	51,446,000.85	471,525,409.23
D01	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	263,741,078.00	156,338,330.38	51,446,000.85	471,525,409.23
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	263,741,078.00	156,338,330.38	51,446,000.85	471,525,409.23
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	68,674,097.55	68,674,097.55
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	263,741,078.00	156,338,330.38	120,120,098.40	540,199,506.78

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	237,503.21	(237,503.21)	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	678,230,300.00	648,376,360.21	29,853,939.79	95.60
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	678,230,300.00	648,376,360.21	29,853,939.79	95.60
210	Бараа, үйлчилгээний зардал	678,230,300.00	648,138,860.21	30,091,439.79	95.56
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	354,202,300.00	352,702,104.00	1,500,196.00	99.58
210101	Үндсэн цалин	230,721,600.00	230,925,176.68	(203,576.68)	100.09
210102	Нэмэгдэл	75,436,800.00	71,741,260.11	3,695,539.89	95.10
210103	Унаа, болон бусад нөхөн олговор	5,306,400.00	3,756,000.00	1,550,400.00	70.78
210104	Урамшуулал	30,250,000.00	30,992,082.21	(742,082.21)	102.45
210105	Гэрээт ажлын хөлс	12,487,500.00	15,287,585.00	(2,800,085.00)	122.42
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,859,600.00	45,859,600.00	-	100.00
210201	Тэтгэврийн даатгал	33,200,400.00	31,915,700.00	1,284,700.00	96.13
210202	Тэтгэмжийн даатгал	3,164,800.00	3,486,000.00	(321,200.00)	110.15

**Арбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210203	ҮОМШӨ ний даатгал	2,531,800.00	2,788,700.00	(256,900.00)	110.15
210204	Ажилгүйдлийн даатгал	633,000.00	697,200.00	(64,200.00)	110.14
210205	Эрүүл мэндийн даатгал	6,329,600.00	6,972,000.00	(642,400.00)	110.15
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,150,100.00	17,150,000.00	100.00	100.00
210301	Гэрэл цахилгаан	3,276,500.00	3,276,469.00	31.00	100.00
210302	Түлш, халаалт	13,700,000.00	13,700,000.00	-	100.00
210303	Цэвэр, бохир ус	173,600.00	173,531.00	69.00	99.96
2104	Хангамж, бараа материалын зардал	64,920,200.00	59,820,319.21	5,099,880.79	92.14
210401	Бичиг хэрэг	4,625,000.00	4,000,000.21	624,999.79	86.49
210402	Тээвэр (шатахуун)	29,390,400.00	30,274,750.00	(884,350.00)	103.01
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	7,094,500.00	3,069,999.00	4,024,501.00	43.27
210404	Ном, хэвлэл	42,500.00	-	42,500.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,416,500.00	7,341,000.00	(1,924,500.00)	135.53
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	18,351,300.00	15,134,570.00	3,216,730.00	82.47
2105	Нормативт зардал	97,410,000.00	92,093,327.00	5,316,673.00	94.54
210501	Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	59,555,900.00	54,239,227.00	5,316,673.00	91.07
210502	Хоол, хүнс	28,437,600.00	28,437,600.00	-	100.00
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл	9,416,500.00	9,416,500.00	-	100.00
2106	Эд хогшил худалдан авах	75,100,900.00	63,839,700.00	11,261,200.00	85.01
210601	Багаж, техник, хэрэгсэл	47,350,900.00	37,339,700.00	10,011,200.00	78.86
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	13,250,000.00	12,000,000.00	1,250,000.00	90.57
210604	Урсгал засвар	14,500,000.00	14,500,000.00	-	100.00
2107	Томилолт, зочны зардал	2,897,700.00	1,828,000.00	1,069,700.00	63.08
210702	Дотоод албан томилолт	2,897,700.00	1,828,000.00	1,069,700.00	63.08
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	9,897,000.00	6,598,510.00	3,298,490.00	66.67
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,000,000.00	3,000,000.00	-	100.00
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	2,216,500.00	1,170,000.00	1,046,500.00	52.79
210803	Даатгалын үйлчилгээ	93,500.00	54,450.00	39,050.00	58.24
210804	Тээврийн хэрэгслийн татвар	62,900.00	44,500.00	18,400.00	70.75
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	47,600.00	33,000.00	14,600.00	69.33
210806	Мэдээллийн технологийн зардал	350,000.00	-	350,000.00	-
210807	Газрын төлбөр	210,000.00	148,900.00	61,100.00	70.90
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	3,916,500.00	2,147,660.00	1,768,840.00	54.84
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	10,792,500.00	8,247,300.00	2,545,200.00	76.42
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,792,500.00	8,247,300.00	2,545,200.00	76.42
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	237,500.00	(237,500.00)	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	237,500.00	(237,500.00)	-
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	-	237,500.00	(237,500.00)	-
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>678,230,800.00</b>	<b>704,558,140.00</b>	<b>(26,327,340.00)</b>	<b>103.88</b>
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>32,997,400.00</b>	<b>35,275,200.00</b>	<b>(2,277,800.00)</b>	<b>106.90</b>
132001	Орон нутгийн төсвөөс	32,997,400.00	35,275,200.00	(2,277,800.00)	106.90
1340	<b>НД-ЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>583,918,400.00</b>	<b>668,117,840.00</b>	<b>(84,199,440.00)</b>	<b>114.42</b>

134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	583,918,400.00	668,117,840.00	(84,199,440.00)	114.42
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	17,532,300.00	1,165,100.00	16,367,200.00	6.65
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	17,532,300.00	-	17,532,300.00	-
120010	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,165,100.00	(1,165,100.00)	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	43,782,700.00	-	43,782,700.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	43,782,700.00	-	43,782,700.00	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	237,503.21	(237,503.21)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	54,140,825.00	(54,140,825.00)	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	-	26.00	(26.00)	-
620003	Үйлчлэх ажилтан	-	25.00	(25.00)	-
620001	Удирдах ажилтан	-	1.00	(1.00)	-
64	ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО	-	-	-	-

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төсвийн гүйцэтгэлийн нэмэлт тайлан байхгүй

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

#### *Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар*

Хөвсгөл аймгийн Арбулаг сумын ЭМТ нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тэгш байдал хүртээмж чанар, аюулгүй байдлыг хангасан үйлчилгээний стандарт, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйг чандлан сахидаг чадварлаг эмч, мэргэжилтэн бүхий төрийн үйлчилгээг төлөвшүүлэх зорилго тавьсан байна.

Арбулаг сумын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Иргэдийг эрт илрүүлэгт хамруулах
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй үзүүлэх
- Үйлчлүүлэгчдэд болон эмч ажилчдад ээлтэй орчин бүрдүүлэх, хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлж тасралтгүй байдлыг хангах

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

#### *Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар*

Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 8 дугаар сард эрүүл мэндийн салбарын багц хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулж, эрүүл мэндийн даатгалын цогц шинэчлэл хийх, стратегийн худалдан авалтыг бий болгох эрх зүйн орчин бүрдүүлсэн. Шинэчлэлийн хүрээнд 2022 онд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ бүрийн өртөг, зардлыг шинэчлэн тооцож, эрүүл мэндийн байгууллагуудыг үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлээр нь Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлж байна. Үүнтэй холбогдуулан Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр батлагдсан<sup>1</sup> 01,02 дугаар

<sup>1</sup> "Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай"

тогтоол, 2022 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр батлагдсан<sup>2</sup> тогтоолуудаар эрүүл мэндийн даатгалын багцын төлбөр хураамжийг нэмэгдүүлэн нэг иргэнд ногдох нормативаар, үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ гэсэн арга хэмжээгээр санхүүжилтийг олгож байна.

**Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:**

1. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн.
2. Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн “Төрийн хэмнэлтийн тухай” хууль хэрэгжиж эхэлсэн.
3. Төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор тогтоосон ба 2022 оны 192 дугаар тогтоолоор эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээг өөрчлөн тогтоосон байна.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ийн дагуу Арбулаг сумын Эрүүл мэндийн төвийн даргын 2022 оны 02 сарын 09-ны өдрийн А/03 тоот тушаалаар дотоод хяналтын багийг 3 хүний бүрэлдэхүүнтэй баталсан байна.

Дотоод хяналтын ажлын хэсэг нь 2022 онд 11 заалт бүхий ажлын төлөвлөгөө хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлуулан, тухайн онд нийт 2 удаа дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна. Дотоод хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүр арилгаж ажилласан байна.

Харин санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтын 1, 2 үе шатны тогтолцоо бий болсон байна гэж үзлээ. **Тухайлбал:** Санхүүгийн үйл ажиллагаанд гүйцэтгэх удирдлага буюу эрхлэгч 1 дүгээр гарын үсэг, нягтлан бодогч 2 дугаар гарын үсэг зурж баталгаажуулж байгаа нь гүйцэтгэх удирдлагын хяналтыг хэрэгжүүлж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Арбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

**Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар:** Арбулаг сумын Эрүүл мэндийн төв нь Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл

<sup>2</sup> “Багц, төлбөрийн хэмжээ, журам батлах тухай

ажиллагаандаа Хөвсгөл аймгийн Засаг даргын 2019 оны А/375 дугаар захирамжаар 2019 онд баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим журам заавар шинэчлэгдсэн, эрүүл мэндийн салбарын байгууллагуудын төсвийн шатлалд өөрчлөлт орсонтой холбоотой нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагаандаа тохируулан боловсруулах шаардлага тулгарч байна. Гэхдээ санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Засгийн газар, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Арбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 68,674.1 мянган төгрөгөөр буюу 14.56 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	237.5	54,140.8	53,903.3
Авлага	32,767.6	0	-32,767.6
Бараа материал	97,739.3	70,440.2	-27,299.1
Үндсэн хөрөнгө	340,780.9	415,618.4	74,837.5
<b>Нийт хөрөнгө</b>	<b>471,525.4</b>	<b>540,199.5</b>	<b>68,674.1</b>
Өр төлбөр		0	0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	263,741.0	263,741.0	0
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>471,525.4</b>	<b>540,199.5</b>	<b>68,674.1</b>

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө данс өмнөх оноос нэмэгдэж, авлага, бараа материал данс буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

1. Тайлант онд мөнгөн хөрөнгө данс 53,903.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь эрүүл мэндийн даатгалын сангаас хүлээн авсан санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлээгүйтэй холбоотой байна.
2. Бараа материал данс өмнөх оноос 27,299.1 мянган төгрөгөөр буурсан нь корона вирусын үеийн вакцины үлдэгдэл тайлант онд зарцуулсантай холбоотой байна.
3. Үндсэн хөрөнгө данс өмнөх оноос 74,837.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 37,724.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 93,161.9 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмжийг улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн сар, улирлын хуваарийг Эрүүл мэндийн яамнаас 1 дүгээр сард баталж ирүүлсэн ба эхний хагас жилийн гүйцэтгэлд үндэслэн 6 дугаар сард Эрүүл мэндийн яамнаас төсвийн сар, улирлын хуваарьт өөрчлөлт оруулсан байна. Тус өөрчлөлтөөр анх баталсан төсвийг 153,002.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Орон нутгийн санхүүжилтийг төрийн үйлчилгээний ажилчдын цалинг хассантай холбоотойгоор 22,504.1 буурч батлагдсан байна.

Эрүүл мэндийн байгууллагын төсвийн төлөвлөлт нь сүүлийн 3 жилийн гүйцэтгэлээр хийгддэг тул төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй хийгдэж байна гэж үзсэн.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 35,275.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 615,142.1 мянган төгрөг нийт 650,417.3 мянган төгрөгийг улсын төсвөөс орлого бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалын сангаас 669,282.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны орлого төвлөрүүлээгүй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 704,558.1 мянган төгрөг нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 54,140.8 мянган төгрөг зарцуулагдаагүй үлдэгдэл байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас 4 дүгээр улирлын гүйцэтгэлийн санхүүжилт 2022 оны 12 сарын 25-ны өдөр төрийн сангийн харилцах дансанд орж ирсний улмаас төлөвлөгөөнд тусгаж зардлын эрхийг нээлгээгүй байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	/мянган төгрөгөөр/		
			Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Нэг иргэнээр тооцсон нормативаар	353,883.5	379285.9	-25,402.4	107.2%
2	Үндсэн тусламж үйлчилгээ	217,475.8	246,214.2	-28,738.4	113.2%
3	Дээд шатны төсвөөс хуваарилсан	43,782.7	43,782.7	0.00	100%
4	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	22,928.5	22,928.5	0.00	100%
5	Нийтлэг үйлчилгээ	12,346.7	12,346.8	0.00	100%
	Дүн	650,417.3	704,558.1	-54,140.8	104.08%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

2021 оны жилийн эцсийн нэмэлт санхүүжилтийн дансны авлагын үлдэгдэл 32,767.6 мянган төгрөгийг барагдуулж нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдлийг төрийн сангийн харилцах данс руу бичилт хийж тайлагнасан байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2022 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Арбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторовын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хаан соёмбо аудитын ХХК-ийн захирал Х.Диймаа, аудитын менежер Л.Магсаржамал нар гүйцэтгэж, хяналтыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын

аудитор Г.Ичинхорлоо, аудитын менежер Б.Тэгшдэлгэр, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Арбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хаан соёмбо аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 04 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 793,130.3 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 15,861.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 буюу 11,103.1 мянган төгрөгөөр тогтоосон.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томилолт, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2022 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ 93,905.2 мянган төгрөгийн 5 гүйлгээ мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дах заалтыг зөрчсөн тул аудитаар зөвлөмж хүргүүлээ.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Хөвсгөл аймгийн Арбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар Шагналын мөнгөнөөс татварын 10% суутгаагүйд төлбөрийн акт тогтоосон, албан шаардлага өгөөгүй, шилэн дансанд мэдээлээгүй 1 зөвлөмж өгсөн ба хэрэгжилт 100% байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	200.0	1	200.0	100
Зөвлөмж	1		1		100
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>200.0</b>	<b>2</b>	<b>200.0</b>	<b>100</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтийг гүйцэтгэлд суурилж олгож байгаагаас шалтгаалан, санхүүжилтийн орлого нэмэгдэж ирснээр дахин эм, багаж тоног төхөөрөмжийн тендер зарлаж, худалдан авалт хийх шаадлагатай байсан ч, тухайн сумын Эрүүл мэндийн төв нь 30,032.8 мянган төгрөгийн эм, 36,451.1 мянган төгрөгийн багаж тоног төхөөрөмж нийт 66,483.9 мянган төгрөгийг тендергүй худалдан авалтаар хийсэн байна.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 141,303.4 мянган төгрөгийн алдаа<sup>3</sup> илэрснээс аудитын явцад 35,822.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 105,481.4 мянган төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналд гарсан дараах алдааг залруулсан. Үүнд:

- ЭМД-аас 2021 оны ковидын авлага 32,767.6 мянган төгрөг авсан ба үүнийг 2022 оны мөнгөн гүйлгээний тайланд орлогын зүйл ангийг буруу сонгож тайлагнасан нь үнэн зөв гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Тайлант онд 3,054.4 мянган төгрөгийг зардал хооронд гүйлгэн эдийн засгийн ангилал буруу сонгож бүртгэснийг залруулсан болно.

Аудитаар нийт 105,481.4 мянган төгрөгийн зөрчил<sup>4</sup> илэрснээс, 105,481.4 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

#### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

#### 5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөөгүй болно

#### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Жилийн эцсийн тооллого хийсэн боловч тооцоо бодоогүй тооллогын бүртгэл 1,852.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”,

<sup>3</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>4</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

12.2.1<sup>5</sup> "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", 20.2.6<sup>6</sup>. заалтуудыг зөрчсөн, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Жилийн эцсийн бараа материал, үндсэн хөрөнгийн тооллогыг чанартай сайн хийж тооллогын үр дүнг хэлэлцэж, тооцоо бодсон актаар баталгаажуулж ажиллах.

**2. Зардалтай холбоотой асуудал**

Илрүүлэлт:

Ковид 19-ын эсрэг вакцин 8,192.3 мянган төгрөгийн үнэ бүхий 426 ширхэг вакцины хугацаа дууссан гэж данснаас хассан ба уг вакциныг устгаагүй ямар нэгэн анхан шатны баримтгүй шууд данснаас хасаж тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7<sup>7</sup> гэсэн заалттай нийцээгүй ба "Иж бүрэн" байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийж тайлагнахгүй байх

**3.Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал**

Илрүүлэлт:

Тайлант хугацааны зардлыг түүвэрлэн үзэхэд цахим төлбөрийн /е – баримт/ баримтгүй 2,231.9 мянган төгрөгийн ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлд бүртгэж тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалттай нийцэхгүй байгаа ба иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Аж ахуйн нэгж, байгууллагуудаас худалдан авалт хийхдээ төлбөрийн е баримтаар баталгаажуулж анхан шатны баримт бүрдүүлж ажиллах.

**4. Шилэн данстай холбоотой асуудал**

Илрүүлэлт:

Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ 93,905.2 мянган төгрөгийн 5 гүйлгээ мэдээлээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь заалтыг зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг цаг хугацаанд иж бүрэн оруулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 09 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа	Мэдээллийг	Буруу тусган илэрхийлсэн	Үүнээс	Зөвлөмж
-------------------	------------	------------	--------------------------	--------	---------

<sup>5</sup> "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө"

<sup>6</sup> "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах"

<sup>7</sup> "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно."

Арбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЭМД-аас 2021 оны ковидын авлагыг Мөнгөн гүйлгээний орлогын тайланд зөрүүтэй тайлагнасан	1	32,767.6			1	32,767.6	1	32,767.6				
дансны харьцаа буруу хийгдсэн	1	3,054.4			1	3,054.4	1	3,054.4				
Дүн	2	35,822.0			2	35,822.0	2	35,822.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/									
			Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
Тооллогын бүртгэлийн дүн зөрүүтэй	1	1,852.0					1	1,852.0				
Анхан шатны баримт дутуу	1	8,192.3					1	8,192.3				
Е баримтгүй гүйлгээ хийсэн	1	2,231.9					1	2,231.9				
Дүн	3	12,276.2					3	12,276.2				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/									
			Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
6.4.5 Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ мэдээлээгүй 5байна.	1	93,205.2							1	93,205.2		
Дүн	1	93,205.2							1	93,205.2		

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

АУДИТОР

Г.ИЧИНХОРЛОО ОГНОО:

БАТАЛГААЖУУЛСАН:

ХААН СОЁМБО АУДИТ ХХК-ИЙН

ЗАХИРАЛ

Х.ДИЙМАА ОГНОО:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Л.МАГСАРЖАЛАМ ОГНОО:

